



САНХҮҮГИЙН ЗОХИЦУУЛАХ ХОРООНЫ ТОГТООЛ

2020 оны 01 сарын 15 өдөр

Дугаар 23

Улаанбаатар хот

Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн
байгуулах баримт бичгийг бүртгэх тухай

Санхүүгийн зохицуулах хорооны эрх зүйн байдлын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.2.2, Хөрөнгө оруулалтын сангийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4, Санхүүгийн зохицуулах хорооны 2014 оны 254 дүгээр тогтоолоор баталсан “Хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах, үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгүүлэх тухай журам”-ын 2.9 дэх хэсгийг тус тус үндэслэн ТОГТООХ нь:


1. “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК-ийн үүсгэн байгуулж буй “Нийслэлийн хөгжлийн сан” хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэхийг Үнэт цаасны газарт үүрэг болгосугай.

2. Энэ тогтоолын 1-д заасан хувийн хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах баримт бичгийг бүртгэсэнтэй холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг “Нийслэлийн өмчит Улаанбаатар хөрөнгө оруулалт, менежмент ҮЦК” ХХК /Д.Отгонсүрэн/-д үүрэг болгосугай.

- 1/ Хөрөнгө оруулалтын санг үүсгэн байгуулах ажиллагааг зохих журмын дагуу гүйцэтгэж, холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа мөрдөн, мэргэжлийн ёс зүйтэй ажиллах;
- 2/ Хаалттай хүрээнд хөрөнгө оруулагчаас татан төвлөрүүлсэн хөрөнгийг холбогдох хууль тогтоомж, нэгж эрхийн танилцуулга, бодлогын баримт бичигт заасны дагуу зарцуулж, нэгж эрх эзэмшигчдийн хуралд тогтмол танилцуулж ажиллах;
- 3/ Хөрөнгө оруулагчийн хууль ёсны эрх ашгийг хүндэтгэн холбогдох хууль тогтоомж, дүрэм, журмыг үйл ажиллагаандаа чанд мөрдөж ажиллах;
- 4/ Үүсгэн байгуулсан “Нийслэлийн хөгжлийн сан” хувийн хөрөнгө оруулалтын сангийн дүрэм, хөрөнгө оруулалтын бодлогын баримт бичиг, сангийн нэгж эрхийн танилцуулгад нэмэлт, өөрчлөлт оруулах тохиолдолд Хороонд тухай бүр мэдэгдэн холбогдох баримт бичгийг бүртгүүлэх;

3. Тогтоол батлагдсанаас хойш ажлын 15 хоногийн дотор Улсын бүртгэлийн ерөнхий газарт мэдээлэл хүргүүлж, тогтоолын хэрэгжилтэд хяналт тавьж, олон нийтэд мэдээлэхийг Ажлын алба /Т.Жамбаажамц/-нд даалгасугай.

ДАРГА



Д.БАЯРСАЙХАН

F:\ajil 2020\Blank\Togtool.doc

151800000046